

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД,
САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2023 оны ... сарын ... -ны өдөр

Дугаар ... / ...

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэх хөрөнгийг төлөвлөх, зарцуулах, тайлагнах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ журмыг мөрдөж ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт зөвлөсүгэй.

3.Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Салбар зөвлөлийн дарга нарт үүрэг болгосугай.

4.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга /Л.Нямгэрэл/, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Ж.Ганбат/-д тус тус даалгасугай.

5.Энэ тушаал гарсантай холбогдуулан Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 88/152 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

САНГИЙН САЙД

Х.НЯМБААТАР

Б.ЖАВХЛАН

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2023 оны ... дугаар сарын ...-ны өдрийн / дугаар хамтарсан тушаалын хавсралт

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙГ ТӨЛӨВЛӨХ, ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2 дахь хэсэгт заасан хөрөнгийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил (цаашид “урьдчилан сэргийлэх ажил” гэх)-ыг санхүүжүүлэхэд зориулан төлөвлөх, зарцуулах, тайлагнах үйл ажиллагаанд энэхүү журмыг баримтална.

1.2. Урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэх хөрөнгө нь улсын болон орон нутгийн төсвөөс бүрдэх бөгөөд хуулиар хориглоогүй санхүүгийн бусад эх сурвалжаас бүрдэнэ.

1.3. Урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэх хөрөнгийг төлөвлөх, зарцуулах, тайлагнахад Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон энэ журмыг дагаж мөрдөнө.

Хоёр. Урьдчилан сэргийлэх ажлын санхүүжүүлэх хөрөнгийг төлөвлөх

2.1. Улсын төсвийн хөрөнгөөр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Зохицуулах зөвлөл нь урьдчилан сэргийлэх дараах зардлыг санхүүжүүлнэ:

2.2.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7, 8, 9, 10 дугаар зүйлд заасан үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэгт заасан чиглэлийн дагуу тооцсон зардал;

2.2.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх зардал;

2.2.3. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 5.1.1, 5.1.2, 5.1.3, 5.1.4 дэх заалтад заасан үүргийг хэрэгжүүлэх зардал;

2.2.4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасан үүргийг хэрэгжүүлэх зардал;

2.2.5. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2, 6.6.4, 6.6.6, 6.6.10 дахь заалтад заасан чиг үүргийг хэрэгжүүлэх зардал;

2.2.6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Зохицуулах зөвлөлийн орон тооны ажлын албаны үйл ажиллагаа, албан хаагчийн цалин хөлс;

2.2.7. хууль тогтоомжид заасан бусад зардал.

2.3. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэхдээ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт заасан эх үүсвэрийн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан санхүүжүүлэх хөрөнгөнд нийцүүлэн, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг болон Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7, 8, 9, 10 дугаар зүйлд заасан үндсэн чиглэлийг тус тус баримтална.

2.4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Салбар зөвлөл нь орон тооны нарийн бичгийн даргын цалин хөлсний зардал

болон өөрийн чиг үүрэгт хамаарах энэ журмын 2.2-т заасан зардлыг санхүүжүүлэхээр тусгана.

2.5.Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийн 8.5.1, 8.5.2, 8.5.3 дахь заалт, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2 дахь хэсгийг үндэслэн урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэх төлөвлөгөөг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийн 8.5.4, 8.5.5 дахь заалтад заасан цаглабрын дагуу тус тус боловсруулж, батлуулна.

2.6.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлд заасны дагуу урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр худалдан авах ажиллагааг төлөвлөнө.

Гурав.Урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэх хөрөнгийг хуваарилах

3.1.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Зохицуулах зөвлөл, түүний ажлын албаны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

3.2.Урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэх хөрөнгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу дараах байдлаар хуваарилна:

3.2.1.аймаг, нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Салбар зөвлөлийн тухайн оны урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэх хөрөнгийн төлөвлөгөөнд туссан ажил, арга хэмжээ, үйл ажиллагааг санхүүжүүлнэ;

3.2.2.сум, дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Салбар зөвлөлд орон нутгийн гэмт хэргийн өсөлт, бууралт, урьдчилан сэргийлэх ажлын үр дүн, тайлан, мэдээг харгалзан санхүүжүүлнэ;

3.3.Аймаг, нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Салбар зөвлөлд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.3 дахь хэсэгт заасны дагуу санхүүжүүлж, хуваарилна.

Дөрөв.Урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэх хөрөнгийг зарцуулах

4.1.Урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг дараах үндсэн чиглэлд зарцуулна:

4.1.1.урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэгт заасан чиглэлийг хэрэгжүүлэхэд;

4.1.2.энэ журмын 2.2.2, 2.2.3, 2.2.4, 2.2.5-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд;

4.1.3.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Зохицуулах зөвлөлийн орон тооны ажлын албаны үйл ажиллагаа, албан хаагчийн цалин хөлс, Салбар зөвлөлийн орон тооны нарийн бичгийн даргын цалин хөлсний зардлыг санхүүжүүлэхэд;

4.1.4.хууль тогтоомжид заасан бусад үүргийг хэрэгжүүлэхэд тус тус зарцуулна.

4.2.Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн зарчмыг баримтална.

4.3.Урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгөөр хийх худалдан авалтын ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулна.

Тав.Урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэх хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, тайлагнах

5.1.Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 192 дугаар тогтоолоор баталсан “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн тайлан, мэдээ гаргах, түүнд дүн шинжилгээ хийх болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг үнэлэх журам”-ын 2.1-т заасан хугацаанд Аймаг, нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Салбар зөвлөл урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлсэн хөрөнгийн

тайланг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Зохицуулах зөвлөлийн Ажлын албанд ирүүлнэ.

5.2.Энэхүү журмын 5.1-т заасан тайланд сум, дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Салбар зөвлөлийн урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлсэн хөрөнгийн тайланг нэгтгэсэн байна.

5.3.Урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад Зохицуулах зөвлөл, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, санхүүгийн хяналт шалгалтын эрх бүхий байгууллага хяналт тавина.

---o0o---